



103

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 4290

Булган

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, Монгол Улсын шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашиглаж байгаа барилга, байгууламжийн паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг шалгаруулах, техникийн асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр түр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: - Ц.Бат-Өлзий /Аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд: - Ү.Бямбасүрэн /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга/

- О.Ихбаяр /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн/
- Б.Ганзориг /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга/
- Д.Гүржав /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн/
- Н.Очирхуяг /Аймгийн мэргэжлийн хяналтын газрын барилгын техник хяналтын улсын байцаагч/

Нарийн бичгийн дарга: - Ж.Хосбаяр /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн/

2. Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулж, шаардлагатай төсөв хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган ажиллаж, хагас бүтэн жилээр тайлагнаж байхыг Зөвлөлийн дарга /Ц.Бат-Өлзий/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА *Ц.Бат-Өлзий* З.БАТЗОРИГ

